

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/76/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 51-261885 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: Э.Цэлмэгбаяр Утас: 51-261740 Цахим хаяг: tselmegbayare@audit.gov.mn “Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл Утас: 99032466 Цахим хаяг: oyungerels.sag@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага	16
5.2 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БУСО	Буянт-Ухаа спортын ордон
ДАСХШҮГ	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, үнэлгээний газар
НА	Нийцлийн аудит
НЗД	Нийслэлийн Засаг дарга
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ҮШББСТ	Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/681

танай _____-ны № _____-т

“ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН
БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫН ТӨВ” ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.НАРАН-ИДЭР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх тэдгээрийн нөлөөг эс тооцвол Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 829.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тус байгууллагын санхүүгийн тайланд “Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ-ыг 2023 онд нэгтгэхдээ санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байсан барилгын засварын ажлын төлбөр 614.3 сая төгрөгийг нотлох баримтгүйгээр “Дуусаагүй барилга” дансанд шилжүүлэн бүртгэсэн;
- Тайлант оны 4 дүгээр улиралд гэрээ хийсэн 2026 онд зохион байгуулах үйл ажиллагааны урьдчилгаанд нийт 165.0 сая төгрөгийг хүлээн авч, урьдчилж орсон орлогоор бус тайлант үеийн үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.3, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын холбогдох заалт, СТОУС 1: Санхүүгийн тайлангийн толилуулгын 15-д “Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэж заасантай тус тус нийцээгүй.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 243 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ “Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ-ыг дуусгалтын тайлан бэлтгээгүйгээр 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдлээр “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-т хүлээлцүүлсэн байсныг тайлант оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар зөвлөмж өгч залруулсан.

Аудитын гол асуудал

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 3 дугаар төв “Буянт-Ухаа спортын ордон”-ын зүүн урд хэсэгт “Спортын барилга байгууламжийн хөгжлийн нэгдсэн төв” ТББ тус ордны газар руу кадастрын цэгээс баруун болон зүүн чиглэлд 10-15м илүү гаргаж барилга барьсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сард хийсэн шалгалтын комиссыг ажиллахад тогтоогдсон нь Газрын тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	11,211,930.95	1,479,878.99
1.1.2	Дансны авлага	142,021,299.41	24,649,298.99
1.1.4	Бусад авлага	7,000,000.00	4,000,000.00
1.1.6	Бараа материал	95,813,632.43	272,000.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	4,950,000.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	260,996,862.79	30,401,177.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	47,361,036,477.81	46,080,004,463.80
1.2.2	Биет бус хөрөнгө	3,478,333.24	3,185,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	47,364,514,811.05	46,083,189,463.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	47,625,511,673.84	46,113,590,641.78
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	826,416,462.11	747,881,318.63
2.1.1.2	Цалингийн өглөг	174,158,431.94	139,967,454.77
2.1.1.3	Татварын өр	628,705,798.91	426,003,260.26
2.1.1.4	НДШ - ийн өглөг	342,212,901.81	221,306,383.69
2.1.1.5	Богино хугацаат зээл	40,416,996.00	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	88,255,831.61	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,100,166,422.38	1,535,158,417.35
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,100,166,422.38	1,535,158,417.35
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	31,372,723,217.16	31,372,723,217.16
2.3.2	- хувийн	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	26,756,359,080.05	26,756,359,080.05
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	985,082,626.00	985,082,626.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(13,588,819,671.75)	(14,535,732,698.78)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	45,525,345,251.46	44,578,432,224.43
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	47,625,511,673.84	46,113,590,641.78

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,745,031,900.00	1,745,355,300.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	1,745,031,900.00	1,745,355,300.00
5	Хүүний орлого	8,294.26	106,027.79
8	Бусад орлого	178,046,894.80	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,636,486,941.23	1,854,552,613.33
10	Ерөнхий ба удирдлагын зардал	488,432,364.50	899,163,189.60
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	62,876,474.80	105,622,716.20
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,265,721.62)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,265,974,413.09)	(1,113,877,191.34)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,265,974,413.09)	(1,113,877,191.34)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(1,265,974,413.09)	(1,113,877,191.34)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,004,053,492.80	1,769,037,119.77
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,602,990,542.95	1,768,357,788.76
	Бусад мөнгөн орлого	401,062,949.85	679,331.01
1.2	Мөнгөн зарлага (-)	1,910,207,216.38	1,748,579,605.48
	Ажиллагчдад төлсөн	670,949,307.00	701,664,923.67
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	16,086,852.06	282,801,057.11
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,847,850.00	129,950.00
	Ашиглалтын зардалд төлсөн	484,998,464.15	483,260,987.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,023,479.00	227,799.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	8,201.07
	Татварын байгууллагад төлсөн	5,682,500.00	20,208,783.92
	Бусад мөнгөн зарлага	719,618,764.17	260,277,903.71
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	93,846,276.42	20,457,514.29
2	Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,208,294.26	27,881,359.02
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,200,000.00	27,815,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	8,294.26	66,359.02
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,674,901.00	24,500,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,210,000.00	16,500,000.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	3,464,901.00	-
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	8,000,000.00

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,466,606.74)	3,381,359.02
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,000,000.00	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	87,300,000.00	33,570,925.27
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	87,300,000.00	33,570,925.27
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(82,300,000.00)	(33,570,925.27)
3.4	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,079,669.68	(9,732,051.96)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,132,261.27	11,211,930.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,211,930.95	1,479,878.99

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	31,372,723,217.16	26,756,359,080.05	985,082,626.00	(11,000,708,815.93)	48,113,456,107.28
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(1,228,906,793.73)	(1,228,906,793.73)
Залруулсан үлдэгдэл	31,372,723,217.16	26,756,359,080.05	985,082,626.00	(12,229,615,609.66)	46,884,549,313.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,359,204,062.09)	(1,359,204,062.09)
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	31,372,723,217.16	26,756,359,080.05	985,082,626.00	(13,588,819,671.75)	45,525,345,251.46
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	166,964,164.31	166,964,164.31
Залруулсан үлдэгдэл	31,372,723,217.16	26,756,359,080.05	985,082,626.00	(13,421,855,507.44)	45,692,309,415.77
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,113,877,191.34)	(1,113,877,191.34)
2025 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	31,372,723,217.16	26,756,359,080.05	985,082,626.00	(14,535,732,698.78)	44,578,432,224.43

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2025 оны		ХЭЛБЭЛЗЭЛ	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
2	Нийт орлого	4,949,490.0	1,745,461.3	(3,204,028.7)	35%
3	Нийт зардал	4,939,044.7	2,859,338.5	(2,079,706.2)	58%
	Үүнээс: Удирдлагын зардал	1,086,589.8	1,297,825.4	211,235.6	119%
4	Татварын өмнөх ашиг/алдагдал	10,445.3	(1,113,877.2)	(1,124,322.5)	-10,664%
5	Цэвэр ашиг алдагдал	9,400.8	(1,113,877.2)	(1,123,278.0)	-11,849%
6	Төсвийн төлбөрт нийт дүн	409,880.1	303,009.8	(106,870.3)	74%
	а/ Орлогын татварт	1,044.5		(1,044.5)	0%
	б/ НДШ	240,330.0	282,801.1	42,471.1	118%
	в/ ХХОАТ	167,785.6	20,208.7	(147,576.9)	12%
	г/ Тээврийн хэрэгслийн татвар	720.0		(720.0)	0%
7	Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	99	40	(59)	40%
9	Нийт цалингийн сан	1,922,640.0	701,664.9	(1,220,975.1)	36%
10	Нэг ажилтны дундаж цалин	1,618.4	1,461.8	(156.6)	90%
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал (төгрөгөөр)	1.00	1.60	0.60	160%
12	Хөрөнгө оруулалт	76,149.6	16,500.0	(59,649.6)	22%
13	Нийт авлага	20,000.0	28,649.3	8,649.3	143%
	Үүнээс: Найдваргүй	-	-	-	-
14	Нийт өглөг	360,254.6	1,535,158.4	1,174,903.8	426%
	Богино хугацаат өр төлбөр	360,254.6	1,535,158.4	1,174,903.8	426%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ нь биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлд спортын шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагааг цогц хэлбэрээр явуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Байгууллагын эрхэм зорилгоо “Биеийн тамир спортыг олон нийтэд сурталчлан таниулах, сургалт дасгалжуулалт хийлгэх, тэмцээн уралдаан зохион байгуулах, дотоодын болон олон улс, тив дэлхийд нэрээ дуурсгасан үндэсний шигшээ багийн залгамж халааг тасралтгүй төрүүлэн гаргах зэргээр нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тус төв нь үндсэн чиг үүргийн хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

- Үндэсний шигшээ багийн тамирчдын биеийн ерөнхий болон тусгай хөгжил, тамирчдын бэлтгэл, цугларалт, сургалт-дасгалжуулалтын орчин, бэлтгэлийн заал танхим, дотуур байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Спортын шинжлэх ухааны шинэ нээлт, ололт, нотолгоонд тулгуурласан техник, арга зүйг тамирчдын ажиллах чадвар, биеийн ерөнхий хөгжлийн болон тусгай хөгжлийн сургалт-дасгалжуулалтад ашиглах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, спортын анагаах ухааны анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Тамирчдын шинжилгээ, судалгааг олон улсын стандартад нийцүүлэн хийж, бүс нутаг, дэлхийн жишгийн хэмжээнд хүргэн хөгжүүлэх, тамирчдын ажиллах чадвар, биеийн ерөнхий хөгжлийн болон тусгай хөгжлийн сорил, тест хийх шинэ техник, технологийн болон спортын хоол судлалын шинэ арга зүйг нэвтрүүлэх;
- Нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, үндэсний болон олон улсын спортын тэмцээн, наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлж иргэдэд чиглэсэн биеийн тамир, спортын төлбөрт үйлчилгээ үзүүлэх;
- Техникийн спортын төрлийн болон галт зэвсэг, техник хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй ажиллагаа, хяналт, хөдөлмөр хамгааллыг мөрдөн ажиллах талаар сургалт зохион байгуулах;
- Аймаг, нийслэл, дүүргүүдийн өсвөр үеийн шигшээ баг, спортын холбоодод үндэсний шигшээ багийн нөөц тамирчин бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
- Бусад холбогдох үйл ажиллагаа.

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас санал болгосноор төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтоодог.

3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

ТӨБЗГ-ын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 158 дугаар тогтоолоор тус ТӨААТҮГ-т захирал-1, менежер-3, алба-5, Бэлтгэл, сургалтын төв бааз-3, нийт орон тоо-99 байхаар бүтэц, зохион байгуулалтыг баталсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 635 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 89 байхаар шинэчлэн тогтоожээ.

Байгууллага үйл ажиллагаандаа Биеийн тамир, спортын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Үүнд:

Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Биеийн тамир, спортын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байна. Уг хуулийн 6 дугаар зүйлд Биеийн тамир, спортын үйл ажиллагааны зарчим, Долоодугаар бүлэгт Биеийн тамир, спортын санхүүжилтийн асуудлыг тус тус тусгажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлого, чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин ерөнхий нягтлан бодогч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд захирлын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар тооцооны нягтлан бодогч-кассын нярвыг ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгчээр томилсноор кассын нярвын үүргийг давхар хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэн үр дүнг үнэлэхэд тус ТӨААТҮГ-ын дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэрэгжилтийн үр нөлөө хангалттай бус байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 25/01-12 дугаартай удирдамжаар тус ТӨААТҮГ-ын 2024 оны удирдлага, санхүү, аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаанд ТӨБЗГ-аас хяналт шалгалт хэрэгжүүлж тайланг ирүүлжээ. Мөн Сангийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр баталсан удирдамжаар Сангийн яамны ДАСХШҮГ-аас тус ТӨААТҮГ-ын 2023, 2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж тайланг ирүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Компанийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 46,113.6 сая төгрөг болж өмнөх оноос 1,511.9 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар буусан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

		/мянган төгрөгөөр/		
ДД	Үзүүлэлт	2024.12.31	2025 .12.31	Зөрүү
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	11,211.9	1,479.9	(9,732.0)
2	Дансны авлага	149,021.3	28,649.3	(120,372.0)

**“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

3	Бараа материал	95,813.6	272.0	(95,541.6)
4	Урьдчилгаа	4,950.0		(4,950.0)
5	Үндсэн хөрөнгө	47,361,036.5	46,080,004.5	(1,281,032.0)
6	Биет бус хөрөнгө	3,478.3	3,185.0	(293.3)
7	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	47,625,511.6	46,113,590.7	(1,511,920.9)
8	Богино хугацаат өр төлбөр	2,100,166.4	1,535,158.5	(565,007.9)
9	Засгийн газрын хувь оролцоо	31,372,723.2	31,372,723.2	-
10	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,756,359.1	26,756,359.1	-
11	Эздийн өмчийн бусад хэсэг	985,082.6	985,082.6	-
12	Хуримтлагдсан ашиг	(13,588,819.7)	(14,535,732.7)	(946,913.0)
13	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	47,625,511.6	46,113,590.7	(1,511,920.9)

Дээрх хүснэгтээс үзэхэд санхүүгийн тайлангийн данстын үзүүлэлтүүд бүгд буурсан байгаа нь 3 дугаар төв буюу Буянт-Ухаа спортын ордонд онооны электрон самбар байрлуулан үйлчилгээ, зохион байгуулалтыг сайжруулснаар өөрийн орлогыг нэмэгдүүлж, Татвар, Нийгмийн даатгалын байгууллагатай өр төлбөр барагдуулах хуваарь гарган ажиллаж, олон жил барагдаагүй авлагыг ТӨБЗГ-т хандаж шийдвэрлэсний үр дүнд авлага, өр төлбөр буурсан байна.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон бараа материалыг Захирлын 2025 оны А/171 дүгээр тушаалаар акталж, үндсэн хөрөнгө данс элэгдлээрээ буурчээ. Тайлант онд тус байгууллага 1,113.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан болон нягтлан бодох бүртгэлийн өмнөх үеийн залруулга бичилт 167.0 сая төгрөгийн зөрүүгээр хуримтлагдсан ашиг данс 946.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу тус байгууллага нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 727 дугаар тогтоолоор баталжээ. Тайлант оны нийт орлогыг 4,949.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,939.0 сая төгрөгөөр буюу 10.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 76.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,745.5 сая төгрөгийн орлоготой, 2,859.3 сая төгрөгийн зардалтай буюу 1,113.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого төлөвлөснөөс 3,204.0 сая төгрөгөөр дутуу буюу 35 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зорилтот түвшний орлогын төлөвлөгөө бодитой бус, өмнөх оны орлогын гүйцэтгэлийг харгалзаж үзэхгүй байгаатай холбоотой байна.

Нийт зардал төлөвлөснөөс 2,079.7 сая төгрөгийн дутуу буюу 58 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төвлөрсөн орлогын хэмжээнд зардлыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд нийт 76.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 16.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

**“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

Тус ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийг орлого зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг 76.1 сая төгрөгөөр баталсан боловч санхүү, мөнгөний дутагдлаас шалтгаалан 16.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө				Гүйцэтгэл /мян.төг/
		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/	
Буянт-Ухаа спортын ордон						
1	Гадна талбайн цас түрэгч /автомат/	ш	2	3,000.0	6,000.0	
2	Зөөврийн компьютер (notebook)	ком	2	2,500.0	5,000.0	
3	Принтер	ш	2	1,000.0	2,000.0	
4	Өнгөт принтер /epson L15150/	ш	1	4,199.9	4,199.9	
5	Довтолгооны самбар	ш	2	1,000.0	2,000.0	16,500.00
6	Гар удирдлага	ш	4	250.0	1,000.0	
7	Программ хангамж	ш	1	9,000.0	9,000.0	
8	Шалны панер /заал 1/4/	ш	210	75.0	15,750.0	
9	Сагсны шит	ш	2	10,000.0	20,000.0	
	ДҮН				64,949.9	16,500.0
Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв						
1	Зөөврийн компьютер (notbook)	ш	2	3,499.9	6,999.8	
2	Өнгөт принтер	ш	1	4,199.9	4,199.9	
	ДҮН				11,199.7	-
	НИЙТ ДҮН				76,149.6	16,500.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч, үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: ТӨБЗГ-ын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 158 дугаар тогтоолоор тус байгууллагыг 99 орон тоотой ажиллахаар тогтоосноос 2025 оны 12 дугаар сарын 04-ний 635 дугаар тогтоолоор 10-аар бууруулж, 89 орон тоотой ажиллахаар баталжээ. Гүйцэтгэлээр 40 орон тоотой ажилласан нь 2 дугаар төв буюу Булган аймгийн Хангал суманд байрлах “Спортын бэлтгэлийн төв” их засвар хийгдээгүй, ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Гадаад томилолт: “ҮШББСТөв” ТӨААТҮГ-ын захирлын 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар дасгалжуулагч 1 ажилтныг Бүгд Найрамдах Беларусь Улсад хамтарсан бэлтгэл, цугларалтад оролцох, туршлага солилцуулах зорилгоор ажиллуулж, 3.7 сая төгрөгийг зарцуулжээ.

ТӨҮГ: Судалгаагаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан дахь Төрийн өмч 31,372.7 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 26,756.4 сая төгрөгөөр бүртгэлтэй боловч улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн хэмжээг 2,020.5 сая төгрөгөөр тусгасан байх тул өөрчлөлтийг хийлгэх шаардлагатай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар орлого, урьдчилж орсон орлого, өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Уламбаяр, аудитор Ж.Болормаа, Д.Энхбаяр нар гүйцэтгэж, захирал С.Оюунгэрэл анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Цэлмэгбаяр, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А-1/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,189.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 31.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, тайлант оны зардлын гүйцэтгэл 2,859.3 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож 28.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төлөвлөлтийн үе шатанд энэхүү хуульд заасан 72 шалгуур үзүүлэлтээс тус байгууллагад хамааралтай шалгуур үзүүлэлтийг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн ба хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 29 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 91 мэдээллээс 90 мэдээллийг хугацаанд нь оруулсан бөгөөд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 -д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.1.5 "аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, нийт 94.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 5 зөвлөмж хүргүүлсэн. Тухайлбал, Засгийн газрын 2022 оны 243 дугаар тогтоолын 3-т заасны дагуу "Буянт-Ухаа спортын ордон" ТӨҮГ-ыг "ҮШББСТ" ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулахдаа дуусгалтын тайлан бэлтгэхгүйгээр 2023 оны 3 дугаар улирлын 47,734.4 сая төгрөгийн хөрөнгө, эх үүсвэрийн дүн бүхий санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдлээр хүлээлцсэн байсан зөрчлийг арилгах зөвлөмжийн дагуу "Буянт-Ухаа спортын ордон" ТӨҮГ-ын 2023 оны 3 дугаар улирлын дуусгалтын балансыг гаргаж баталгаажуулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг захирлын 2025 оны 8 дугаар сарын 31-ний өдөр албан бичгээр ирүүлсэн байна.

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,838.5 сая төгрөгийн алдаа зөрчилд өгсөн төлбөрийн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянаж, үнэлэхэд хэрэгжилт 83.5 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	1,838.5	4	1,233.6	67.1%
Зөвлөмж	1		1		100%
Нийт дүн	5	1,838.5		1,233.6	83.5%

Өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өр төлбөрийг барагдуулах талаар нийгмийн даатгалын болон татварын байгууллагатай гэрээ байгуулж сард төлөх төлбөрийн хуваарь гаргаж барагдуулж байгаа боловч орлогын дутагдал, санхүүгийн боломжгүйгээс шалтгаалж, бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус ТӨААТҮГ-ын харьяа 3 төвийн хэмжээнд нийт 142,505 м² газар эзэмших эрхийн зөвшөөрөлтэй боловч газрын төлбөр төлөөгүй, шүүхийн маргаантай асуудал зэргээс шалтгаалан тус байгууллагад газрын гэрээ болон гэрчилгээний эх хувиуд байхгүй, egazar.gov.mn цахим санд нэвтрэх эрх олгогдоогүй асуудлыг нягтлах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд, Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг улсын төсвийн эх үүсвэрээр бэлтгэсэн гэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 829.3 сая төгрөгийн зөрчил² илэрсэн бөгөөд 614.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 215.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Нийт залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

5.1 Албан шаардлага

1. “Буянт-Ухаа спорт ордон” ТӨҮГ-аас 2023 онд балансаас балансад шилжиж ирсэн тус ордны засварын ажлын хөлс, урьдчилж гарсан зардал 614.3 сая төгрөгийг нотлох баримтгүйгээр “Дуусаагүй барилга” дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 6 дугаар бүлэг, Санхүүгийн тайлангийн тодруулга “Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлангийн тодруулгад ... дараах мэдээллийг системтэй арга хэлбэрээр харуулна” 11-д Дуусаагүй барилга: “Дуусаагүй барилга гэсэн зүйл ангиар бүртгэсэн баригдаж буй барилгатай холбоотой гарсан шууд материал, шууд хөдөлмөр болон нэмэгдэл зардлуудын хуримтлагдсан дүн, барьж эхэлсэн огноо, дуусгалтын хувь болон бусад мэдээллийг тодруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөж, зохих баримтыг бүрдүүлэн засварын зардлыг капиталжуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар тооцооны нягтлан бодогч-кассын нярваар ажиллаж байсан ажилтныг ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгчээр томилсноор кассын нярвын үүргийг давхар хэрэгжүүлж байгаа нь санхүү, бүртгэлийн дотоод хяналтын зарчим алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын чиг үүргийн давхцал үүсгэж, байгууллагын санхүү, бүртгэлийн дотоод хяналтын зарчим алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн зөрчлийг арилгах, холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Урьдчилж орсон орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 19-ний өдрийн хооронд байгуулсан 6 гэрээгээр 2026 онд зохион байгуулах үйл ажиллагааны урьдчилгаанд тайлант онд тухайн байгууллагад төлсөн нийт 165.0 сая төгрөгийг Урьдчилж орсон орлогоор бус Үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “... аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын “Богино хугацаат өр төлбөр” хэсгийн 8-д “Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж “Урьдчилж орсон орлого” дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед дебитлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны орлогыг зөв ангилан бүртгэж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: “Интеллектуал колл центр” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан “Үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах” тухай 25/51 дугаартай гэрээгээр 2025.12.01-2025.12.31-ний хооронд БУСО-ны заалыг нийт 50.0 сая төгрөгөөр “Шинэ жилийн үйл ажиллагаа зохион байгуулах”-д зориулан түрээслүүлсэн нь “Үйлчилгээний үнэ тариф шинэчлэн батлах тухай” захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар баталсан тарифаас хэт доогуур үнээр тооцон гэрээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.9 “улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох” гэсэн заалт болон холбогдох тушаалаар баталсан тарифыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг улсын төсвийн эх үүсвэрээр бэлтгэсэн гэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.	1	16,500.0			1	16,500.0						
Дүн	1	16,500.0			1	16,500.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	Тоо	Дүн	
Тус ТӨААТҮГ-ын 3-р төв БУСО-оос 2023 онд балансаас балансад "Урьдчилж төлсөн зардал, тооцоо" дансаар шилжин ирсэн 614,301.9 мянган төгрөгийг "БУСО-ны барилгын засварын ажлын дүнг бүртгэсэн байсан" гэсэн тайлбартайгаар "Дуусаагүй барилга" дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.	1	614,301.9			1	614,301.9							
"Интеллектуал колл центр" ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан "Үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах" тухай 25/51 дугаартай гэрээгээр 2025.12.01-2025.12.31-ний хооронд													

**“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

БУСО-ны заалыг нийт 50.0 сая төгрөгөөр "Шинэ жилийн үйл ажиллагаа зохион байгуулах"-д зориулан түрээслүүлсэн нь "Үйлчилгээний үнэ тариф шинэчлэн батлах тухай" захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар баталсан тарифаас хэт доогуур үнээр тооцон гэрээлсэн байна.	1	50,000.0					1	50,000.0				
2025 оны 09 дүгээр сарын 18 өдрөөс 12 дугаар сарын 19-ний өдрийн хооронд байгуулсан 6 гэрээгээр 2026 онд зохион байгуулах үйл ажиллагааны урьдчилгаанд тайлант онд тухайн байгууллагад төлсөн нийт 165.0 сая төгрөгийг Урьдчилж орсон орлогоор бус Үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.	1	165,000.0					1	165,000.0				
Захирлын 2025.04.02-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар тооцооны нягтлан бодогч-кассын нярваар ажиллаж байсан ажилтныг ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгчээр томилсноор кассын нярвын үүргийг давхар хэрэгжүүлж байна.	1				1							
Дүн	4	829,301.9			2	614,301.9	2	215,000.0				
Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 91 мэдээллээс 90 мэдээллийг хугацаанд нь оруулсан бөгөөд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1						1					
Нийт дүн	5	829,301.9			2	614,301.9	3	215,000.0				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 708/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/76/НА - СТА - ТӨААТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын захирлын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар тооцооны нягтлан бодогч-кассын нярваар ажиллаж байсан ажилтныг ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгчээр томилсноор кассын нярвын үүргийг давхар хэрэгжүүлж байгаа нь нь албан тушаалын чиг үүргийн давхцал үүсгэж, санхүү, бүртгэлийн дотоод хяналтын зарчим алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "... алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагад санхүү, бүртгэлийн дотоод хяналтын зарчим алдагдах нөхцөл бүрдсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал(Б.Наран-Идэр), Ерөнхий нягтлан бодогч (Д.Алтанчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"БОРЛДВАЙД ФАЙНЭНС
АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
С.ОЮУНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 709/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/76/НА -СТА -ТӨААТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Буянт-Ухаа спорт ордон” ТӨҮГ-аас 2023 онд балансаас балансад шилжиж ирсэн тус ордны засварын ажлын хөлс, урьдчилж гарсан зардал 614,301,909.93 (зургаан зуун арван дөрвөн сая гурван зуун нэг мянга есөн зуун есөн төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийг нотлох баримтгүйгээр “Дуусаагүй барилга” дансанд шилжүүлэн бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 6 дугаар бүлэг, Санхүүгийн тайлангийн тодруулга “Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлангийн тодруулгад...дараах мэдээллийг системтэй арга хэлбэрээр харуулна” 11-д Дуусаагүй барилга: “Дуусаагүй барилга гэсэн зүйл ангиар бүртгэсэн баригдаж буй барилгатай холбоотой гарсан шууд материал, шууд хөдөлмөр болон нэмэгдэл зардлуудын хуримтлагдсан дүн, барьж эхэлсэн огноо, дуусгалтын хувь болон бусад мэдээллийг тодруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “... алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөж, зохих баримтыг бүрдүүлэн засварын зардлыг капиталжуулж бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал (Б.Наран-Идэр), Ерөнхий нягтлан бодогч (Д.Алтанчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“ВОРЛДВАЙД ФАЙНЭНС
АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ӨРДЭНЭЦЭЦЭГ

С.ОЮУНГЭРЭЛ